



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймаг дахь Хүнс Аж Ахуй Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/113/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2022 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн

Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.24 № 10
танай _____ ны № _____ т

ХАА-н МЭРГЭЖИЛ СУРГАЛТ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ Н.ПҮРЭВСАЙХАН
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ХАА-н Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ХАА-н Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020012

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>197,430,862.34</u>	<u>166,194,808.34</u>
33	АВЛАГА	150,000.00	-
335	Бусад авлага	150,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	150,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	197,280,862.34	166,194,808.34
351	Түүхий эд материал	28,186,851.00	28,311,023.00
35110	Тусгай зориулалттай материал	26,568,351.00	27,087,323.00
35130	Эм боох материал	1,618,500.00	1,223,700.00
354	Хангамжийн материал	169,094,011.34	137,883,785.34
35410	Бичиг хэргийн материал	665,900.00	454,860.00
35420	Аж ахуйн материал	32,947,800.00	35,465,800.00
35430	Сэлбэг хэрэгсэл	8,708,986.00	8,208,986.00
35440	Түлш, шатах тослох материал	5,899,200.00	231,000.00
35450	Барилгын засварын материал	55,000.00	-
35460	Хүнсний материал	5,827,152.00	2,957,185.00
35470	Бусад хангамжийн материал	114,989,973.34	90,565,954.34
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,820,874,998.81</u>	<u>2,350,878,267.04</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,820,874,998.81	2,350,878,267.04
392	Биет хөрөнгө	1,685,136,998.81	2,215,140,267.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,521,192,436.83	2,008,668,756.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	(151,080,220.93)	(137,890,310.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	159,214,145.87	118,269,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(89,859,586.86)	(28,600,476.78)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	430,526,655.38	371,579,396.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	(219,232,102.89)	(192,613,254.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	91,308,180.00	74,354,090.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(86,917,435.86)	(27,851,718.05)
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,655,000.00	24,011,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,127,259.73)	(6,395,384.73)
39217	Ном	8,457,187.00	11,609,169.00
393	Биет бус хөрөнгө	135,738,000.00	135,738,000.00
39301	Программ хангамж	16,418,500.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(16,418,500.00)	(500,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	135,738,000.00	135,738,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,018,305,861.15</u>	<u>2,517,073,075.38</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,018,305,861.15</u>	<u>2,517,073,075.38</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,018,305,861.15	2,517,073,075.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,918,734,371.38	1,918,734,371.38

51101	Өмч: - төрийн	1,918,734,371.38	1,918,734,371.38
512	Хуримтлагдсан үр дүн	(25,815,062.60)	472,952,151.63
51210	Өмнөх үеийн үр дүн	(25,815,062.60)	(25,815,062.60)
51220	Тайлант үеийн үр дүн	-	498,767,214.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	125,386,552.37	125,386,552.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,018,305,861.15</u>	<u>2,517,073,075.38</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	916,079,637.00	689,912,150.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	278,227,137.00	2,809,450.00
120	Нийтлэг татварын бус орлого	278,227,137.00	2,809,450.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	278,227,137.00	2,809,450.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,700,400.00	2,809,450.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	275,526,737.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	637,852,500.00	687,102,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	637,852,500.00	687,102,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	637,852,500.00	687,102,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	772,685,428.66	826,610,338.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	772,685,428.66	826,610,338.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	686,591,758.93	721,066,826.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	425,991,608.84	434,191,265.50
210101	Үндсэн цалин	315,973,205.31	312,110,676.50
210102	Нэмэгдэл	69,816,323.46	85,972,370.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,390,400.00	10,374,000.00
210104	Урамшуулал	31,811,680.07	25,734,219.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,896,108.42	57,648,045.68
210201	Тэтгэврийн даатгал	37,691,645.26	40,643,976.99
210202	Тэтгэмжийн даатгал	4,379,481.16	4,473,390.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,399,726.30	3,517,013.35
210204	Ажилгүйдлийн даатгал	776,059.28	816,057.66
210205	Эрүүл мэндийн даатгал	7,649,196.42	8,197,606.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,263,329.25	37,215,511.00
210301	Гэрэл, цахилгаан	5,909,629.25	5,602,311.00
210302	Түлш, халаалт	23,829,200.00	29,468,200.00
210303	Цэвэр, бохир ус	2,524,500.00	2,145,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,054,941.00	40,869,505.00
210401	Бичиг хэрэг	1,687,133.00	1,809,660.00
210402	Тээвэр, шатахуун	1,492,800.00	2,306,327.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,497,500.00	2,572,894.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,667,200.00	3,155,191.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,912,460.00	12,237,224.00
210408	Бараа материал акталсны зардал	4,797,848.00	18,788,209.00
2105	Норматив зардал	7,758,082.00	3,385,017.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	597,450.00	566,300.00

210502	Хоол, хүнс	7,160,632.00	2,501,317.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	317,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,324,860.00	11,136,700.00
210604	Урсгал засвар	3,324,860.00	11,136,700.00
2107	Томилолт, зочны зардал	151,200.00	-
210702	Дотоод албан томилолт	151,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,019,600.00	896,570.00
210803	Даатгалын үйлчилгээ	359,700.00	470,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	659,900.00	305,870.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,132,029.42	135,724,212.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,598,827.25	20,767,288.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	134,533,202.17	114,956,924.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,093,669.73	105,543,511.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	522,900.00	58,268,040.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	12,715,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	43,716,140.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	522,900.00	1,836,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	85,570,769.73	47,275,471.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	85,570,769.73	47,275,471.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>143,394,208.34</u>	<u>(136,698,188.00)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	10,142,739.77
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	10,142,739.77
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(10,142,739.77)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>143,394,208.34</u>	<u>(146,840,927.77)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,918,734,371.38	125,386,552.37	(169,209,270.94)	1,874,911,652.81
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,918,734,371.38	125,386,552.37	(169,209,270.94)	1,874,911,652.81
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-

C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	143,394,208.34	143,394,208.34
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,918,734,371.38	125,386,552.37	(25,815,062.60)	2,018,305,861.15
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,918,734,371.38	125,386,552.37	(25,815,062.60)	2,018,305,861.15
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,918,734,371.38	125,386,552.37	(25,815,062.60)	2,018,305,861.15
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	498,767,214.23	498,767,214.23
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,918,734,371.38	125,386,552.37	472,952,151.63	2,517,073,075.38

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	640,552,900.00	694,507,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,700,400.00	7,404,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,700,400.00	7,404,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,700,400.00	7,404,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,700,400.00	2,809,450.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,595,150.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	637,852,500.00	687,102,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	637,852,500.00	687,102,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	637,852,500.00	687,102,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	640,552,900.00	681,129,510.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	640,552,900.00	681,129,510.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	554,459,230.27	575,585,998.18

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	423,980,119.27	434,191,265.50
210101	Үндсэн цалин	313,961,715.74	312,110,676.50
210102	Нэмэгдэл	69,816,323.46	85,972,370.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,390,400.00	10,374,000.00
210104	Урамшуулал	31,811,680.07	25,734,219.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,031,485.50	57,648,045.68
210201	Тэтгэврийн даатгал	34,827,022.34	40,643,970.07
210202	Тэтгэмжийн даатгал	4,379,481.16	4,473,390.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,399,726.30	3,517,013.35
210204	Ажилгүйдлийн даатгал	776,059.28	816,057.66
210205	Эрүүл мэндийн даатгал	7,649,196.42	8,197,613.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,087,529.25	31,547,311.00
210301	Гэрэл, цахилгаан	5,909,629.25	5,602,311.00
210302	Түлш, халаалт	26,653,400.00	23,800,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,524,500.00	2,145,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,238,500.00	12,780,476.00
210401	Бичиг хэрэг	1,759,500.00	1,857,120.00
210402	Тээвэр, шатахуун	1,492,800.00	2,306,327.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,497,500.00	2,572,894.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,070,200.00	3,052,791.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,418,500.00	2,991,344.00
2105	Норматив зардал	11,493,576.00	9,495,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	718,600.00	171,500.00
210502	Хоол, хүнс	9,924,976.00	4,076,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	850,000.00	5,247,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,369,060.00	11,491,700.00
210604	Урсгал засвар	3,369,060.00	11,491,700.00
2107	Томилолт, зочны зардал	151,200.00	-
210702	Дотоод албан томилолт	151,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,019,600.00	896,570.00
210803	Даатгалын үйлчилгээ	359,700.00	470,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	659,900.00	305,870.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,088,160.25	17,535,230.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,088,160.25	17,535,230.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,093,669.73	105,543,511.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	522,900.00	58,268,040.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	12,715,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	43,716,140.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	522,900.00	1,836,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	85,570,769.73	47,275,471.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	85,570,769.73	47,275,471.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	13,377,790.00

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	13,377,790.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	13,377,790.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	13,377,790.00
223001	Бусад хөрөнгө	-	13,377,790.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(13,377,790.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	690,102,700.00	647,231,828.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	690,102,700.00	633,854,038.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	631,834,200.00	575,585,998.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	458,782,900.00	434,191,265.50
210101	Үндсэн цалин	328,096,500.00	312,110,676.50
210102	Нэмэгдэл	91,691,900.00	85,972,370.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,391,100.00	10,374,000.00
210104	Урамшуулал	28,603,400.00	25,734,219.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,715,800.00	57,648,045.68
210201	Тэтгэврийн даатгал	46,244,400.00	40,643,970.07
210202	Тэтгэмжийн даатгал	4,867,800.00	4,473,390.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,894,300.00	3,517,013.35
210204	Ажилгүйдлийн даатгал	973,600.00	816,057.66
210205	Эрүүл мэндийн даатгал	9,735,700.00	8,197,613.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,698,700.00	31,547,311.00
210301	Гэрэл, цахилгаан	5,612,200.00	5,602,311.00
210302	Түлш, халаалт	23,898,600.00	23,800,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,187,900.00	2,145,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,812,600.00	12,780,476.00
210401	Бичиг хэрэг	1,867,500.00	1,857,120.00
210402	Тээвэр, шатахуун	2,309,000.00	2,306,327.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,572,900.00	2,572,894.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,054,200.00	3,052,791.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,009,000.00	2,991,344.00
2105	Норматив зардал	19,275,600.00	9,495,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	172,300.00	171,500.00
210502	Хоол, хүнс	13,851,600.00	4,076,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,251,700.00	5,247,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,433,200.00	11,491,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,939,800.00	-
210602	Тавилга	10,000,000.00	-
210604	Урсгал засвар	11,493,400.00	11,491,700.00
2107	Томиллолт, зочны зардал	121,000.00	-
210702	Дотоод албан томиллолт	121,000.00	-

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,020,000.00	896,570.00
210803	Даатгалын үйлчилгээ	480,000.00	470,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	305,870.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	120,000.00	120,000.00
210807	Газрын төлбөр	20,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,974,400.00	17,535,230.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,974,400.00	17,535,230.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,268,500.00	58,268,040.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,268,500.00	58,268,040.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,715,900.00	12,715,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	43,716,200.00	43,716,140.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,836,400.00	1,836,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	13,377,790.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	13,377,790.00
223001	Бусад хөрөнгө	-	13,377,790.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	690,102,700.00	694,507,300.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	687,102,700.00	687,102,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	687,102,700.00	687,102,700.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,000,000.00	7,404,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	2,809,450.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,595,150.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймгийн Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, нийгмийн түншлэлд тулгуурласан насан туршийн чанартай сургалт явуулах. Булган аймаг дахь ХАА-н Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2010 онд үүсгэн байгуулагдаж бүрэн дунд боловсрол олгох ХАА-н салбарт төрөлжсөн мэргэжлийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТ, ЧИГЛЭЛ:

- Ойжуулагч- 2.5 жил, 1 жил
- Сүү боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан – 2.5 жил, 1 жил
- Жимс, жимсгэнийн аж ахуйн фермер- 2.5 жил, 1 жил
- Хүнсний ногооны фермер – 2.5 жил, 1 жил
- Хүлэмжийн аж ахуйн фермер – 2.5 жил, 1 жил
- ХАА-н машин механизмын ашиглалт, засварчин – 2.5 жил, 1 жил
- Тракторын механик - 1 жил
- Малын асаргаа – 1 жил
- Фермерийн аж ахуй эрхлэгч – 1 жил
- Зөгийчин, зөгийн аж ахуй эрхлэгч- 1 жил
- Малчин-1 жил

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 7 дугаар хавсралтын дагуу байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцсийн жилийн байдлаар гарган тайлагналаа. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 4 зорилго, 8 зорилтын хүрээнд 38 арга хэмжээ тусгаж хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийж хэрэгжилтийг тодорхойллоо. Нийт төлөвлөсөн 38 арга хэмжээний хэрэгжилт дараах гүйцэтгэлтэй байна.

- Арга хэмжээ бүрэн хэрэгжин зорилтот түвшинд хүрсэн 32 арга хэмжээ
- Зорилт, арга хэмжээний гол үр дүн нь гарч эхэлж байгаа 2 арга хэмжээ
- Гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа 3 арга хэмжээ
- Цуцалсан болон хэрэгжилтийг үнэлэх боломжгүй 1 арга хэмжээ байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний **хэрэгжилт 97 %-ийн** гүйцэтгэлтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймгийн Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “ дунд “ гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 714 598.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10 718.98 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7 503.29 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган аймгийн Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 498,767.21 мянган төгрөгөөр буюу 24.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.0	00.0	00.0
Авлага	150.0	00.0	(150.0)
Бараа материал	197,280.86	166,194.81	(31,086.05)
Үндсэн хөрөнгө	1,820,875.09	2,350,878.27	530,003.18
Нийт хөрөнгө	2,018,305.86	2,517,073.07	498,767.21
Өр төлбөр	00.0	00.0	00.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,018,305.86	2,517,073.07	498,767.21
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,018,305.86	2,517,073.07	498,767.21

2021 онд ХАА-н МСҮТ нь Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслийн хүрээнд тоног төхөөрөмж багаж хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлого нийт 3,883.0 төгрөг, үүнээс бараа материалын тайлангийн аж ахуйн материал 2,098.0 төгрөг, бусад хангамжийн материалд 1,785.0 төгрөгийн материалыг орлогод авч тусгай зориулалт, бичиг хэрэг, аж ахуй, сэлбэг хэрэгсэл, түлш, шатах тослох, барилгын засвар, хүнс, бусад хангамжийн материал хэрэгсэл зэрэг бараа материалыг хүлээн авч нийт нэмэгдсэн дүнгээр 73,598.0 төгрөгийн бараа материалыг орлогот авч ажиллаа. Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3 төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 сарын 18-ны өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгийн олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” 271 дүгээр тогтоолын хавсралтын 2.1, 2.1.1 дэх заалт Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2021 оны 04 сарын 27, 2021 оны 12 сарын 24 ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ХАА-н МСҮТ захирлын 2021 сарын 04 сарын 28-ны өдрийн А/25, 2021 оны 12 сарын 28-ны өдрийн А/62 тоот тушаалаар нийт 18,788.2 төгрөгийн эргэлтийн хөрөнгийн акталсан. Акталсан бараа материал нь суралцагчдын хичээл үйлдвэрлэл сургалт, дадлага хийх болон аж ахуйн ажилд хэрэглэгдэж эвдэрч хэмхэрсэн, дууссан бараа материал байлаа. Бараа материалын тодруулгын тайланд нийт 104,684.2 төгрөгийн хасагдсан бүртгэлд тайлагнагдсан болно.

Тайлант жилд үндсэн хөрөнгийн дансанд нийт 655,102.9 төгрөгийн орлого бүртгэн 297,883.6 төгрөгийн хасагдсан зардал гарч жилийн эцсийн тайлангаар 2,744.7 төгрөгийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй үндсэн хөрөнгийн товчоор тайлагнасан болно. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслийн хүрээнд өвлийн нарлаг хүлэмж, хаа-н мэргэжлийн ангиудын дадлагын байрны засвар, халаалтын зуухны өргөтгөл, малын бага эмчийн лаборатори тоног төхөөрөмж багаж, багш хөгжлийн төвд 3 үйлдэлт принтер 553,053.4 үнэ төлбөргүй хүлээн авсан орлогод тусгаж ХАА-н МСҮТ-ийн багш, ажилчдын шинэ санал, санаачилга хандиваар сургуулийн номын санд мэргэжлийн ангиудын сурах бичиг, төсвийн хөрөнгөөр 13,377.8 төгрөгийн худалдан авалт хийж хөрөнгийн дансаар бүртгэн авч, үлдэх өртөггүй тэг үнэлгээтэй 297,883.6 төгрөгийг үндсэн хөрөнгийг мөн үе өмнөх онуудын тооллогоор, санхүүгийн программаар элэгдэл бодож, өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлж баталгаажуулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271-р тогтоолын хэрэгжилтийг ханган төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт актлан устгах, дахин үнэлгээ тогтоох саналыг хоёр удаа хүргүүлж 2021 оны 01 сарын 12 –ний 06,13 дугаар тогтоол, 2021 оны 05 сарын 11-ны 141, 135 дугаар тогтоол, 2021 оны 11 сарын 11-ны өдрийн 521, 502 дугаар тогтоолын шийдвэрээр цаашид ашиглах боломжтой нийт 77,661.87 төгрөгийн орлогыг дахин үнэлгээгээр орлого авч хөрөнгийг бүртгэж тайлагналаа.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,517,073.07 мянган төгрөг болж 498,767.21 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Булган аймгийн Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 1,335,520.29 мянган

төгрөг буюу 45.7 хувиар, нийт зардал өмнөх оноос 826,610.3 мянган төгрөгөөр буюу 7.0 хувиар тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Булган аймаг дахь ХАА-н МСҮТ нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,190,628.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,190,628.4 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 503,525.7 мянган төгрөгөөр бууруулан 687,102.7 мянган төгрөг, өөрийн орлогыг 3,000.0 мянган төгрөгөөр нийт 690,102.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 687,102.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, өөрийн үйл ажиллагаанаас 3,000.0 мянган төгрөг, урсгал үйл ажиллагаанд 647,231.8 мянган төгрөгийг зарцуулж, 47,275.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 647,231.8 мянган төгрөг буюу батлагдсан төлөвлөгөөнөөс 6.3 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 24,591.63 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 8,067.75 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлыг 151.39 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 32.1 мянган төгрөг, норматив зардлыг 9,780.2 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 11,94.5 мянган төгрөг, томилолтын зардлыг 121.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн зардлыг 123.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,439.2 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилт хүлээн аваагүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй.

3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Булган аймаг дахь Хөдөө аж ахуйн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 онд нийт 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах ёстойгоос хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

УСНББОУС 17-ийн 13 параграфт Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах шинжтэй биет зүйлсийг хэлнэ Үүнд: Бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэнд ашиглах, бусдад түрээслэх эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа ба Нэгээс дээш тайлант үед ашиглагдахаар хүлээгдэж буй гэсэн заалтын дагуу хөрөнгийг зөв ангилж бүртгэх. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 99.4-т "Хөгжлийн бэрхшээлтэй болон 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна" гэсэн заалтаар амралтын хоногийг тооцоолж бодож олгох. Аудитын явцад асуудлын бүртгэлтэй холбоотой асуудлаар зөвлөмж зөвлөгөөг өгч ажилласан болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар засварын аудит 8 сард орж тухайн 103,097.60 мянган төгрөгийн 9-н асуудал илэрсэн. Жилийн эцсээр өөр алдаа үүсээгүй ба 9 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангасан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	-	-	-	-	-	-	
Албан шаардлага	-	-	-	-	-	-	
Зөвлөмж	9	103,097.60	9	103,097.60	-	-	
Нийт дүн	9	103,097.60	9	103,097.60	-	-	

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар бараа материалын ангилал, зардлын ангилал дээр анхаарч ажиллах бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар тоон мэдээлэлгүй нэг зөвлөмж авсан ба шаардлагатай зүйлсийг аудитын явцад зөвлөж ажилласан болно.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй.

4.2 Акт

Аудитын явцад акт байхгүй.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх хэмжээний алдаа зөрчил гаргаагүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд 3 927.0 мянган төгрөгийн 20 ширхэг мэдээллийн самбар бүртгэгдсэн байна. Энэ нь УСНББОУС 17-ийн 13 парагафт Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах шинжтэй биет зүйлсийг хэлнэ Үүнд: Бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэнд ашиглах, бусдад түрээслэх эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа ба Нэгээс дээш тайлант үед ашиглагдахаар хүлээгдэж буй гэсэн заалтын дагуу хөрөнгийг зөв ангилж бүртгэж байхыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Эд хариуцагчийг хөрөнгөтэй тулган ашиглах боломжтой хөрөнгө болон актлах хөрөнгийн жагсаалтыг гарган хүсэлт гаргах.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Групптэй ажилтны амралтын бодохдоо групптэй хүнд нэмж олгох 5 хоногийг нэмж амруулаагүй 5 хоногийн амралтын мөнгийг ажилласан цалингаар бодож олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99.4-т "Хөгжлийн бэрхшээлтэй болон 18 насанд хүрээгүй, ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна" гэсэн заалтаар амралтын хоногийг тооцоолж бодож олгож байхыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомжийг баримтлан амралтын хоногийг тооцох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/


д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ХАА-ийн МСҮТ	2	3,927.0	-	-	-	-	-	-	2	3,927.0
	Дүн	2	3,927.0	-	-	-	-	-	-	2	3,927.0

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

"БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:



Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ :



Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:



Ж.ЭНХЦООДОЛ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Д.АНХБАЯР